



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 седэр

Дугаар 43

Мандалговь

Г Хөрөнгө дахин үнэлж  
худалдах тухай Г

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3, 6.3.4 дэх заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сайнцагаан сумын ИТХ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 15,000,000 /арван таван сая/ төгрөгийн анхны өртөгтэй, 2,083,333 /хоёр сая наян гурван мянга гурван зуун гучин гурван/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 61-61 ДУА улсын дугаартай Nissan X-Trail маркын автомашин, Луус сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 85,659,500 /наян таван сая зургаан зуун тавин есөн мянга таван зуун/ төгрөгийн анхны өртөгтэй, 57,306,205 /тавин долоон сая гурван зуун зургаан мянга хоёр зуун таван/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй цэцэрлэгийн барилгыг барилгын доорх газрын хамт, захиргааны журмаар хураагдсан моторыг тус тус хавсралтын дагуу тогтоосон үнээр худалдахыг зөвшөөрсүгэй.
2. Эд хөрөнгийг хууль журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.
3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Сайнцагаан сумын ИТХ /Б.Эрдэнэтуюя/, Луус сумын Цэцэрлэг /Л.Цогзолмаа/-т тус тус даалгасугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 сарын 16-ны өдрийн 34 дүгээр тогтоол, 2017 оны 04 сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

8100108

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Уганбаяр/-т үүрэг болгосугай.



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны ...  
сарын 17 өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт

Худалдах хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр төрөл	Эзэмшигч байгууллага	Балансын үнэ	Худалдах доод үнэ	Худалдах хэлбэр
1	Nissan X-Trail автомашин	Сайнцагаан сумын ИТХ	15,000,000	2,000,000	Дуудлагын худалдаа
2	Цэцэрлэгийн барилга	Луус сумын Цэцэрлэг	85,659,500	12,500,000	Дуудлагын худалдаа
3	Elemax SH-3900 мотор	Захиргааны журмаар хураагдсан		275,000	Шууд